

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ
ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1 Төслийн нэр.....	2
1.2 Төслийн зорилго.....	2
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	2
1.4 Төслийн хүчин чадал	2
1.5 Үйлдвэрийн ашиглалтын технологи	3
1.6 Эцсийн бүтээгдэхүүн.....	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	5
2.1 Төслийн байршил:	5
2.3 Уур амьсгал.....	6
2.4 Ус зүй.....	7
2.5 Ургамал зүй.....	7
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөө:.....	8
3.2 Хөрс ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөө:.....	8
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	9
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	14
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ	22

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

Хэнтий аймгийн Дархан сумын нутаг орших “Хайлуур жоншны хүдрийг флотацийн аргаар баяжуулах” төсөл

1.2 Төслийн зорилго

“Флюорит Ланд Фактори” ХХК-ийн жоншны хүдэр баяжуулах үйлдвэр /ЖБҮ/ нь жоншны хүдрийн баяжмалыг боловсруулснаар салбарын хэмжээнд ашигт малтмал /жоншны хүдэр/-ыг хаягдалгүй технологиор ашиглах боломжийг бодитойгоор хэрэгжүүлэх бололцоог олгож байгаагаараа онцлогтой төсөл юм. “Флюорит Ланд Фактори” ХХК нь Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор олборлолтоор хайлуур жоншны хүдэр бэлтгэдэг Сүхбаатар аймгийн Уулбаян, Дархан сумын нутагт орших жоншны уурхайнууд, аж ахуйн нэгжүүдтэй гэрээ хийж CaF₂-ын хүдрийг худалдан авч флотацийн аргаар баяжуулж фторт кальцийн агуулга өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэн техник, эдийн засаг, зохион байгуулалтын томоохон арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр зорьж байгаа юм.

1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Флюорит ланд фактори” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011818287
Регистрийн дугаар	6487939
Хаяг	Улаанбаатар хот, Сонгинохайрхан, 12-р хороо, өнөр хороолол, 1, 112 тоот,
Утас	88053300

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

1.4 Төслийн хүчин чадал

Хэнтий аймгийн Дархан суманд баригдан ажиллаж буй жоншны Баяжуулах үйлдвэр нь жилд 150.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай, хагас автоматчилагдсан тоног төхөөрөмжтэй, технологийн процессийн хяналтын систем, эрдсийн болон орчны шинжилгээний лабораторитай үйлдвэр байна. Үйлдвэрийг ашиглалтанд оруулснаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл хангагдаж бүс нутгийн үйлдвэрлэл, нийгмийн хөгжилд ихээхэн түлхэц болно.

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.5 Үйлдвэрийн ашиглалтын технологи



1.6 Эцсийн бүтээгдэхүүн

Жоншны баяжуулах үйлдвэр байгуулах нь манай улсын болон Хэнтий аймгийн эдийн засгийн хөгжлийг дээшлүүлэх, мөн бүс нутгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байна. Ялангуяа ашигт малтмалын хуулийн дагуу ашигт малтмал ашигласны төлбөрийн зохих хувийг тухайн үйлдвэрлэл явуулж буй орон нутагт нь өгөх болсон нь тухайн бүс нутгийг хөгжүүлэхэд түлхэц болж байна. Мөн үйлдвэрийн орчинд орон сууц болон ахуйн зориулалттай барилга байгууламжууд баригдсан нь орон нутгийн хөгжилд зохих нөлөө үзүүлж, тухайн бүс нутагт ажлын байр шинээр бий болгон, баяжуулах үйлдвэр, засварын газар зэрэг томоохон байгууламжууд бий болсон. Үйлдвэрийн төлөвлөгдсөн хүчин чадлын дагуу үйл ажиллагааны эхний жилээс эхлэн жил бүр 150.0 мян.тн хүдэр баяжуулан ФФ-95 маркийн 40770 тн жоншны баяжмал гарган авна. Баяжмалаа Бор-Өндөр өртөө хүртэл тээвэрлэн Бор-Өндөрөөс төмөр замаар Дорноговь аймгийн Замын-Үүд өртөөнд хүргэн БНХАУ-д борлуулахаар эдийн засгийн тооцоог хийсэн. Жоншны баяжмалыг борлуулах гэрээ хэлэлцээрийн шатанд явж байна. Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу жилд дунджаар 3.4 тэрбум.төг, төслийн нийт хугацаанд 17.3 тэрбум.төг улс болон орон нутгийн төсөвт оруулах боломжтой тул Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмэр оруулахаар байна.

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ
ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.7 Төслийн дэд бүтэц

Орд нь манай орны эдийн засгийн зүүн бүсийн дэд бүтэц эрчимтэй хөгжиж буй нутагт багтдаг. Хамгийн ойрхон томоохон суурин газар нь 10 мянга орчим хүн амтай Дархан сум бөгөөд эмнэлэг сургууль, төмөр зам, хувийн хэвшлийн жижиг үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүд ба үүрэн телефон, шатахуун түгээх станцууд тогтмол ажиллагаа явуулдаг. Эдийн засгийн дэд бүтэц харьцангуй сайн төвлөрсөн эрчим хүчний шугамаас гадна төмөр замын сүлжээтэй. Сүүлийн жилүүдэд хайлуур жонш, төмрийн хүдэр зэрэг эрдсийн түүхий эдийг олборлох, тэдгээрийг нэг цэгт төвлөрүүлэн тээвэрлэж, баяжуулж, экспортлох ажлууд эрчимтэй эхэлсэнтэй уялдан ажиллах хүч эрс өссөн. Хүн амын ихэнх нь уул уурхай, мал аж ахуй эрхэлнэ.

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Төслийн байршил:

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт L-49-75 нэрлэбэр бүхий хавтгайд, Улаанбаатар хотоос зүүн урагш 350 км, төмөр замын Бор-Өндөр өртөөнөөс зүүн тийш 40 км, Дорноговь аймгийн Иххэт сумын төвөөс баруун тийш 20 км зайд оршино. 2318001354 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий талбай нь дараах солбилцолд оршино.



Хүснэгт №. 2 Төслийн талбайн координат

№	Уртраг	Өргөрөг
1	413358.16	5131527.55
2	413360.55	5131688.94
3	413479.55	5131687.25
4	413481.25	5131597.93
5	413504.12	5131597.93
6	413504.25	5131579.75
7	413481.25	5131579.75
8	413481.25	5131526.11

Зураг № 1 Төслийн талбайн байршлын зураг

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ
ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2.2 Төслийн физик газарзүй

Хэнтийн уулархаг мужийн зүүн өмнөд хэсгийн Дорнод Монголын тэгш талд шилжиж буй тал хээрийн бүсэнд хамаарагдана.

Уул зүй ба гадаргуугийн хэлбэр: Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхэлдээ 1280-1400м-ийн өндөрлөгтэй уул толгод, ухаа гүвээ тэдгээрийн хоорондох тэвш маягийн хөндий тал зонхилсон тал хээрийн бүсэд хамаарагдана.

Талбайн хэмжээнд хамгийн өндөрлөг цэг нь 1447.56 м өндөртэй Их бор овоо, хамгийн нам дор цэг нь 1271.1 м өндөрлөг бүхий Бор-Өндрийн булгийн хөндий юм. Усан сүлжээ муу хөгжсөн, талбай түүний дүүргийн хэмжээнд байнгын устай гол, горхи ховор. Ордоос зүүн урагш шорвог устай жижиг нуурууд байх ба сүүлийн жилүүдэд зөвхөн зуны улиралд хур бороо ихтэй үед усаар дүүргэгдэх боловч дороо хатаж ширгэдэг болсон. Ордоос 5-6 км-ийн зайд орших, 2700-2900 л/ц ундаргатай гар ба гүний худгуудаас нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээгээ хангадаг.

2.3 Уур амьсгал

Тус орд газар нь уур амьсгалын хувьд эрс тэс, улирлын болон өдөр, шөнийн температур их зөрүүтэй ажиглагддаг. Уур амьсгал нь хоногийн болон улирлын температур, агаарын даралт ихээр хэлбэлздэг, эх газрын эрс тэс бөгөөд өвөл нь урт, хүйтэн -38 хэм, зун нь +40 хэм хүрдэг. Хур тунадасны жилийн дундаж хэмжээ Бор Өндөр тосгоны цаг уурын станцын мэдээгээр 244мм орчим байна.

Анхны цас 10-р сарын дундуур орох ба 4-р сарын төгсгөл болтол цас бүрэн хайлж дуусахгүй. Салхины хурд тогтмол 4.4-10 м/сек байдаг боловч өвөл, хаврын цагт зарим үед 28м/сек хүрдэг.

Судалгааны талбай нь жилийн дөрвөн улирал ээлжлэн солигддог эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын температурын зөрүү их. Өвөл нь -37.5 хэм хүртэл хүйтэрнэ. Зун хамгийн их халж +34.9-өөс +40 хэм хүрнэ. Жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 277 мм бөгөөд үүний 70 гаруй хувь нь зуны улиралд бууна. Жил бүрийн 10-р сарын сүүл үеэс цас орж хүйтний улирал эхэлдэг. Салхины хурд 6-8 м/сек-ээс 18 м/сек хүрнэ. Заримдаа түүнээс ч хүчтэй шороон шуурга шуурна. Цасан

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ
ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

бүрхүүл ихэвчлэн жил бүрийн 11-р сарын 2 дугаар хагаст эхлэн тогтож, дараа жилийн 3-р сарын сүүлч, 4-р сарын эхээр бүрэн хайлдаг. Жилд дунджаар 79-95 орчим хоногийн туршид харьцангуй бага зузаантай цасан бүрхүүл тогтдог боловч уул толгодын хойд ташлаг болон хөндий хотгорын ай савын хэсэгт цасан бүрхүүлийн хамгийн их зузаан 18-20 см хүрдэг.

2.4 Ус зүй

Судалгааны талбайд ой мод, намаг шавар байхгүй. Зуны улирлын сүүлч, намрын ширүүн аадар борооны дараа хуурай сайруудаар хэмхдэс чулуу зөөвөрлөсөн түр зуурын үерийн ус урсдаг. Гадаргуугийн нам дор хэсгүүдэд оршдог жижиг нуур тойрмууд нь агаарын хур тунадсаар тэжээгдэнэ.

2.5 Ургамал зүй

Тус сумын нутаг ботаник газар зүйн мужлалаар дээгүүр, Монголын хээрийн тойргийн Нялгын дүүрэгт хамаарна. Уулын хээрт: Цахилдаг, алаг өвст, хиаг-хялганат, бужмаг, хонгорзул, улалж, бут бударгана, харгана, халгай, буурцагт өвсний төрөл зонхилно. Тал хээрт: Үетэн хялганат, хазаар өвс, хиаг-хялганат, шарилж, лууль, дэрс болон амт чанар, шимт сайтай үетэн, буурцагт, алаг өвсний төрлийн ургамал зонхилно. Мөн гол, булаг, нуур тойрмын хөвөөгөөр хиаг, хазаар өвс, салхин ерхөг, дэрс, харгана, адамсын агь, хэрс зэрэг ургамал ургадаг ба сумын урд говирхог талаараа таана, мангир, хөмүүл, ерхөг, үетэн хялганат, алаг өвс, жижиг бутан үетэн, ботуульт ургамал зонхилон ургадаг байна. Сумын нийт бэлчээрийн 4.5 хувь нь цэвэр бэлчээр, 59 хувь нь сөөгт бэлчээр, 22 хувь нь чулуурхаг бэлчээр, 14.5 хувь нь довонтой бэлчээр байна.

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ
ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ
ТОДОРХОЙЛОЛТ**

3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөө:

Алс хайлуур жоншны ордын район бол манай орны хамгийн эрс тэс уур амьсгалтай, ургамал бүрхэвч сайтай нутаг. Энэ бүс нутагт уур амьсгалын чийглэг, хуурай байдлыг илтгэх үзүүлэлт болох дулаан улирлын хур тунадас, газрын гадаргын ууршуулах чадварын харьцаа 0.14-өөс их байдаг

Уг төсөл хэрэгжих талбай нь хүний суурьшлын бүс буюу Дархан сумын төвөөс зүүн хойш 36км зайтай, тухай район нь жоншны хэд хэдэн уурхай, баяжуулах үйлдвэртэй байгаа зэргээс агаар орчинд нөлөөлж бохирдуулах тоос, хүнд машин механизмуудын утаа зэргээр бага зэргийн бохирдсон байна.

Агаар орчныг бохирдуулах үндсэн эх үүсвэрийг байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж 2 ерөнхий хэсэгт хувааж үзнэ. Агаарын бохирдлын нилээд аюултай эх үүсвэрт хүний үйл ажиллагаанаас хамааралтай бохирдолт ордог ба энэ нь ихэвчлэн үйлдвэртэй холбоотой

3.2 Хөрс ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөө:

Төсөл хэрэгжиж буй газрын хөрсөн бүрхэвч нь ялзмаг хуримтлалын давхарга нь бараан хүрэн, хүрэн өнгөнийх нь байдал ялзмагийн хуримтлалтай шууд холбоотой. Бүдэг илэрсэн бөөмөрхөг бүтэцтэй, жижиг сайр чулуу байнга бага хэмжээгээр агуулсан байдаг. Доод хил нь тод ялгардаг. Зузаан нь янз бүр 10см-ээс 30-35 см хүртэл хэлбэлзэнэ. Шилжилтийн ялзмагт давхарга тод бор, цайвар бор өнгөтэй бусад давхаргуудаас арай хурц туяатай, нягтавтарт, хил зааг нь тод, зузаан нь 10-25 см байдаг.

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ
ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Алс (дальний)-ийн хайлуур жоншны ордын урт хэсэг/биет1,1а,2/-ийг ашиглах” уул уурхайн төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”–ын 2-р хэсэгт тусгасаны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”- ын дагуу боловсруулав

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “ХДТ” ХХК -аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 3 БОМТ нийт зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Зардал (сая.төг)
	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4.500.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10.500.0
3	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	3.000.0
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2.500.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2.500.0
6	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1.000.0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1.000.0
	2024 оны нийт зардал	25.000.000

Тус төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч тухайн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж болохуйц, бодиттой арга хэмжээг төлөвлөн тусгахыг эрхэм болголоо. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2024 оны 1 жилийн хугацаанд менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **25.000.000 /хорин таван сая төгрөг/** зарцуулахаар төсөвлөгдсөн байна.

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөлийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж
Агаарын чанар								
1	- Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил, - Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох -Бутлуурын үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт	Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах мөрдөж ажиллах	Үйл ажиллагааны хүрээнд	-	3.0	-	3.0	Жил бүр
		Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах сургалт явуулах	Үйл ажиллагааны хүрээнд	-	500.0	-	500.0	2024 оны 5-7 сар
Хөрсөн бүрхэвч								
2	Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх.	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтанд хяналт тавих	Үйл ажиллагааны турш	-	-	Гэрээний дагуух төлбөр		2024 онд
		Шимт хөрсний овоолго хийх хадгалах	Үйл ажиллагааны турш	-	500.0	-	500.0	-
		Уурхайн орчны замыг стандартын дагуу тавих, тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш	-	500.0	-	500.0	
Дуу чимээ								

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

3	Ашиглагдаж буй машин тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ	Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх	Үйл ажиллагааны турш	-	-	-	-	Тогтмол	
		Дуу шуугианы хэмжилт (2 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмийн ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах	Үйл ажиллагааны турш	-					2024 онд
Усан орчин									
5	Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Усыг хэмнэлттэй хэрэглэх	Үйл ажиллагааны турш					Үйл ажиллагааны зардлаар	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
		Ус ашиглуулах дүгнэлт гаргуулан гэрээ байгуулан зөвшөөрөл авч, төлбөрийг барагдуулах	Үйл ажиллагааны турш						
Нийт 4.500.0									

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян,төг	Хэрэгжүүлэх хугцаа ба давтамж	Баримтлах эрх зүй баримт бичиг
1	Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа болон ашиглалтын явцад уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах зорилгоор нөхөн сэргээхэд техникийн нөхөн сэргээлтийн гол зорилт юм.	Тус сумын удирдлагуудтай зөвшилцөн уул уурхай, дэд бүтцийн нөлөөгөөр эвдрэлд орж орхигдсон 1 га - аас багагүй талбайд техникийн болон нөхөн сэргээлт хийх	Үйл ажиллагааны дуусмагц		Үйл ажиллагааны зардлаар	-	“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008 MNS5916:2008 MNS5917:2008
2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын удирдлагуудтай зөвшилцөн 1 га талбайд мод тарих					
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	0.5 га талбайд 100 ширхэг мод тарина.	Төслийн талбайд		Үйл ажиллагааны зардлаар	2024 онд	
Нийт					10.500.0		

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах жрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах	0.5 га талбайд дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийх	Төслийн талбайд	-	-	Үйл ажиллагааны зардлаар		“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008 MNS5916:2008 MNS5917:2008
2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын удирдлагуудтай зөвшилцөн 1 га талбайд мод тарих						
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	0.5 га талбайд 100 ширхэг мод тарина.	Төслийн талбайд	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2024 онд	
Нийт							3.000.0	

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2024 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нөлөөлөд өртөх түүх соёлын биет өв	Түүх, соёлын өв дурсгалуудын талаарх мэдээлэлд анхааралтай хандах, сэргээх ажилд оролцох	Үйл ажиллагааны явцад	-	-	-	-	2024онд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
		Түүх соёлын биет өв олдсон тохиолдолд хамгаалалтад авах	Төслийн талбайд	-	-	-	-	2024 онд	

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Хамгаалах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Нийт төсөл хэрэгжих талбай барилг байгууламжинд	–	–	–	–	Жил бүр	Гамшгаас хамгаалах тухай хууль
		Галын сараа байгуулах	Үйл ажиллагааны турш	–	–	–	–	2024 онд	
		Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	–	–	–	–		
		Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюулгүй байдалд хяналт тавих, зориулалтын агуулахад хадгалах	Үйл ажиллагааны турш	–	–	–	–	Жил бүр	
Нийт						2.500.0			

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Хамгаалах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар авах	Үйл ажиллагааны турш	–	–	–	–	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
		Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах	Үйл ажиллагааны турш	–	–	–	–	Жил бүр	
		Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, аль болох олон газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш	–	–	–	–		
1	Ахуйн хатуу хог хаягдлаар газрын гадарга бохирдох;	Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай хийх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах.	Төслийн талбайн бүх барилга байгууламжуудад				250.00	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Хог хаягдал, ШТМ-ын хаягдал хурын усаар дамжин гүний усыг бохирдуулах	Унд ахуйн усыг лабораторын шинжилгээнд тогтсон хуваарийн дагуу шинжлүүлж байх	Төслийн талбай дахь худгийн усанд				ОХШХ-т тусгасанаар	IV улиралд	MNS 3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх MNS 0900:2005
Нийт		2.500.0							

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Энэхүү төслийг хэрэгжүүлэх явцад БОННУ-ий тайлан, БОМТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав. ОХШХ нь байгаль орчин, нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. Цаашдаа БОХТ-г улам боловсронгуй болгох, байгаль орчин, нийгэм-эдийн засгийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг илүү нарийвчлан тогтооход ашиглагдах боломжтой. ОХШХ-ийг жил бүр шинэчлэн боловсруулж, тухайн оныхоо эхэнд БОНХАЖЯ-аар батлуулж, оны эцэст тэдгээрийн биелэлтийг БОНХАЖЯ-д тайлагнана. Хяналт шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлнэ. Энэ хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлыг төсөл хэрэгжүүлэгч тал бүрэн хариуцах тул мэргэжлийн хүн авч ажиллуулах эсвэл мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллах хэрэгтэй.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийит зардал, төг	тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Хөрс								
1	Хөрсний механик бүрэлдэхүүн	Төслийн талбайн нэг цэг сонгон хөрсний шинжилгэ хийлгэх.	2024 он	Жилд 2 удаа	80.0	160.0	Хөрсийг агрохими, хүнд мяталл, эрүүл ахуй, механик бүрэлдэхүүний шинжилгээг хийлгэнэ	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,
2	Хөрсний агрохимин үзүүлэлт							
3	Хөрсний хүнд металлын үзүүлэлт							
	Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт							

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Агаар									
4	Агаар	Төслийн талбайн нэг цэг сонгон шинжилгээ хийлгэх.	2024 он	Жилд удаа	1	100.0	200.0	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ хийлгэх Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос, H ₂ S ₃ , NH ₃) шинжилгээ хийлгэж БОШТЛ-ын багажаар хийнэ	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох
5	Дуу шуугиан		2024 он	Жилд 1 удаа					
Усны шинжилгээ									
6	Усны ерөнхий үзүүлнлт	Усны эх үүсвэрээр	2024	Жилд удаа	2	50.0	100.0	Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналтбохирдол)
Нийт							1.000.000		

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Харилцсан албан тушаалтан	Баримтлах стандарт, арга, аргачлал
			2024он				
			Cap 5	Cap 3	Cap9		
1	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	+	-	+	ХАБ-ын мэргэжилтэн	БОМТ-нд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
2	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	ХАБ-ын мэргэжилтэн	
3	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	Уурхайн эмч,	
4	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	ХАБ-ын мэргэжилтэн	
5	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹ -д заасны дагуу Байгаль орчны аудит хийлгэх	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	ХАБ-ын мэргэжилтэн	
Нийт 1.000.000							

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАЙЛУУР ЖОНШНЫ ХҮДРИЙГ ФЛОТАЦИЙН АРГААР
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН
ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Хэнтий аймгийн Дархан сумын ажлын хэсэгт танилцуулах	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	2024 оны 11 сарын 1 дотор	Үйл ажиллагааны зардлаар	Тус уурхайн байгаль орчны мэргэжилтэн	Хэнтий аймгийн Дархан сум